

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№ 07/280

НШУС

2007

МОНГОЛЧУУДЫН МЭДЭЭЛЛИЙН ХАРИЛЦААНЫ АНХНЫ ХЭЛБЭРҮҮД

Л.Норовсүрэн*, Н.Ариунзаяа**

* МУИС, НШУС, Сэтгүүл зүйн тэнхмийн багш, шинжлэх ухааны доктор (Sc.D.), МУИС-ийн профессор

** Сэтгүүл зүйн магистр

Түлхүүр үг: мэдээ занги, юм мэдээ, дохио мэдээ, болзмол ба болзмол бус, хадны зураг, сураг тавих, малын им тамга.

Орчин үеийн олон нийтийн мэдээллийн хөгжил нь эртний хүмүүсийн мэдээ занги солилцох эгэл хэлбэрүүдээс эхтэй юм. Иймээс барагцаагаар манай гариг дээр хүн үүссэн үеэс мэдээллийн эхлэл ямар нэг хэмжээгээр тавигдсан гэж үзэх үндэстэй. Аль тэртээх хүн сүргийн үеэс үүдэлтэй мэдээ занги солилцох эрэлт хэрэгцээ нь зохион байгуулалттай хүмүүсийн нэгдэл бүрэлдэн тогтож эхлэх үед бүр ч их өсчээ. Ялангуяа хөдөлмөрийн анхны хэлбэрүүд үүссэн нь мэдээллийн харилцааг урагш үлэмж давшуулсан байна. Хүн төрөлхтний элэнц өвөг анхны болхи хайрга чулуун

зэвсэг хийж байгалийн бэрхшээлийг бага боловч даван туулах боломж олоход тэдний хооронд хамгийн эгэл харилцаа үүсч эхэлжээ. Байгаль цаг уурын шинэ нөхцөл буюу их мөстлөгийн үед амьдарч байсан эртний хүмүүсийн багаж зэвсэг харьцангуй сайжирч, хэл яриа үүсч, гал хэрэглэх болсон төдийгүй, агуй, хонгил, оромж овоохой эзэмшиж, энгийн халхавч, нөмрөг мэтийн хувцас өмсөх болсон бөлгөө. Ийнхүү хүний амьдрах арга сайжирч, оюун ухааны хөгжил хурдсах тутам мэдээлэл солилцох хэрэгцээ өссөн байна.

Орчин үеийн түүхчид, өнө эртний уламжлалтай монголчуудын хөгжил дэвшлийн арвин түүхийг манай нутаг дээр хүн амьдарч эхэлсэн үе буюу одоогоос 750 мянгаад жилийн тэртээгээс хөөн үздэг болов. Үүнтэй нэг адил монголын нийтлэлийн эртний үр хөврөл

болох мэдээ зангийн солилцоо хамгийн эгэл болхи хэлбэрээрээ ч гэсэн тэрхүү үед эхэлсэн байх гэж үзэхэд хүргэдэг. Учир нь нэгэнт хүн үүссэн л бол тэд харилцахгүйгээр яавч аж төрж чадахгүй билээ. Мичин хүнээс орчин үеийн хүн үүсч асан 40-30 мянган жилийн өмнөх үеэс хүний нийгэм, соёл иргэншил, арьс өнгө бүрэлдэн тогтох эхний шинжүүд мэдэгдэж эхэлсэн нь мэдээллийг илүү өргөн хүрээнд, тодорхой зорилготой солилцох хэрэгцээг төрүүлж эхэлжээ.

Эртний хүн аюулгүй амьдрах, байгаль цаг уурын бэрхшээлийг даван туулах, орон байр, хүнс тэжээлээ бэлтгэх зэрэгт харилцан нэвтрэлцэж, хамтран тэмцэх шаардлага зайлшгүй гардаг байв. Өнөө үеийн үйлдвэрлэлийн анхны үр болох эртний хүмүүсийн хөдөлмөрийн тэрхүү үйл ажиллагаа нь тэдний бүлэг, хэсэг хийгээд бодгал тус бүрийн хувьд өөр өөр зорилго, шинж чанартай байв. Самар жимс түүх, ан гөрөө хийх, оромж овоохой барих зэргээр хөдөлмөрийн төрөл хэлбэр олшрох тутам хүмүүс танин мэдэгдээгүй олон шинэ зүйлтэй тулгарч,

бусдын хүч туслалцааг эрж, тэр хэмжээгээрээ хэл мэдээ авч, өгөлцөх харилцаанд татагдан ордог байсан нь лавтай.

Эртний хүмүүс мэдээлэл солилцох хэрэгцээгээ ахуй амьдралд хамгийн ойр, гарын дор байгаа арга хэрэгсэл, үйлдлээр дамжуулан хангадаг байжээ. Тэд-

«
Эртний хүмүүс мэдээлэл солилцох хэрэгцээгээ ахуй амьдралд хамгийн ойр, гарын дор байгаа арга хэрэгсэл, үйлдлээр дамжуулан хангадаг байжээ. Тэдгээрийг ерөнхийд нь үйлдлээр харилцах, эд юмсаар харилцах гэсэн хоёр хэсэгт ангилан үзэж болох бөгөөд харилцааны үр дүн нь ихэвчлэн товч бөгөөд тойм төдий мэдээлэл өгч, авалцахаар хязгаарлагддаг байжээ.

»

гээрийг ерөнхийд нь үйлдлээр харилцах, эд юмсаар харилцах гэсэн хоёр хэсэгт ангилан үзэж болох бөгөөд харилцааны үр дүн нь ихэвчлэн товч бөгөөд тойм төдий мэдээлэл өгч, авалцахаар хязгаарлагддаг байжээ. Тийнхүү харилцах арга хэлбэрүүдийг мэдээ занги солил-

цохдоо юуг ашиглаж байгаагаар нь дохио мэдээ, юм мэдээ, зураг мэдээ, тамга мэдээ, ам мэдээ, элч мэдээ хэмээн ангилж болох юм гэж үзэж байна. Үүнд:

1. Дохио мэдээ. Энэ нь балар эртний хүний харилцааны анхны хэлбэр бөгөөд арга хэрэгслийн хувьд биеийн үйлдлийн харилцаанд хамаарах юм. Учир нь нүүрний хувирал, нүдний харц, гар хөлийн хөдөлгөөн, дуу хоолойн өнгө

аяс, өндөр нам зэрэг үйл хөдлөлөөр утга санаа илэрхийлдэгт оршино. Дохио зангааны харилцаа нь эхэн үедээ айж түгших, хөөрч баярлах, хориглон зогсоох, зөвшөөрөн дэмжих гэх мэт ерөнхий утгатай цөөн хэдэн санааг илэрхийлдэг байснаа, хөгжлийн явцад мэдээлэл дамжуулахад чиглэсэн хүний үйлдэл, нүүр нүдний хувирал, хөдөлгөөн олширсонтой холбоотойгоор улам бүр олон утга санааг ялган харилцах болжээ. Тэр цагт хүний дохиж зангах үйлдлийн хурд, хүч, эвсэл зэрэг нь мэдээлж байгаа үзэгдэл, үйл явдлын шинж чанарыг ямар нэг хэмжээгээр ялгаж чаддаг байжээ. Үнэндээ тэр эрт балар цагийн хүн тэгэж ингэж дохиод, тийм ийм санааг илэрхийлдэг байсан гэж өнөөдөр тодорхойлон хэлэх боломжгүй нь мэдээжийн хэрэг юм. Гэвч өнөөдрийг хүртэл хадгалагдсаар байгаа дохиж зангаж харилцах харилцааны хэлбэрүүдээс ургуулан бодвол бас ч зарим зүйлийг төсөөлөх бололцоотой юм. Эрт үед зөвхөн харилцааны арга болж байсан дохио зангаа нь орчин үед улс үндэстнүүдийн ёс журам, зан үйлийг илтгэх цогц соёл болтлоо хөгжжээ. Эрдэмтэн судлаачид дохио зангааг харилцааны харьцангуй бие даасан хэрэглүүр, хүмүүсийн харилцааны хэлэхүйн бус хэрэгсэл гэх мэтээр томъёолох болсон байна. Өнөөдөр хүн ардын дунд дэлгэрсэн зочлох зочлуулах,

мэндэлж хүндлэх, үдэж угтах, шүтэж бишрэх, тоглож наадах, мал аж ахуй эрхлэх, ан ав хийх зэрэгт хэрэглэдэг ёс заншлын элдэв үйлдэл нь цөм уламжлалт дохио зангааны үлдэц гэж үзэж болно. Жишээ нь зочин угтахад урьтаж мориноосоо буугаад хөтлөн тосох нь хүндэтгэж байгаагийн шинж, гэрт ороод хоёр өвдгийг нугалж сөхрөн суух нь дээдсийн амгаланг айлтгаж хүндэтгэл үзүүлж байгаагийн дохио, баруун гарыг зүрхний угт тавьж мэндлэх нь чин сэтгэлээсээ хүндэтгэж байгаагийн бэлгэдэл, хоёр алгыг дээш сунгаж толгойноос дээш гарган тэргүүнээ бөхийх нь их буян хишигт талархан сүслэх санаа гэх мэтээр олон зүйл нэрлэж болно.

Харин орилж хашгирах дохионы хувьд дууны хүч, өнгө аялгуу нь хэрхсэнийг мэдэх гол шинж болдог байсан байх. Жишээ нь араатан дайсан халдах, байгалийн гамшиг нүүрлэх аюулын дохиог өгч, үтэр түргэн зайлж зугатахыг шаардах үед сандарч тэвдсэн байдал илтгэн, гараар огцом хурдтай зангаж даллан, хахир муухай өнгөөр хүчтэй орилж хашгирах жишээтэй байсан биз ээ. Түүнчлэн ажил төрлөө бүтээгээд амарч хооллох ч юм уу, үр хүүхэд, эсрэг хүйстнээ энхрийлж дотночилох дохио буюу үйлдэл, дуу авиа нь тайван намбалаг хөдөлгөөн, аядуу зөөлөн өнгөөр илэрдэг байсан байж

таарна. Эдгээр тохиолдолд дохио зангаа нь дуу авианы хавсарга байдалтай болсон гэж үзмээр байдаг.

Дохио зангааны мэдээ нь зөвхөн цөөн буурай буюу олон хүн нэг дор байж бие биесээ харах, дуу дуугаа авалцахуйц нөхцөлд хэрэглэгддэг байсан нь тодохой билээ. Харин хүний дуу хүрэхгүй хол газраас харилцахдаа түүдэг асаах, утаа май тавих, үзэгдэхүйц юмаар даллаж дохиолох аргыг хэрэглэдэг байжээ. Гал утаа үүсгэж сэрэмж дохио өгөх арга монгол болон дорно зүгийн ард түмний дунд өргөн дэлгэрч, урт удаан хугацаанд хэрэглэгдсэн байна. Энэ аргыг зөвхөн аюул түгшүүр зарлах төдийд бус, алсаас харилцан хэл мэдээ авалцах, хэрэг явдлын бүтэмжийг илтгэх, хэлэлцэж тохирсондоо үнэнч байгаагаа илэрхийлэх зэрэг олон утгаар хэрэглэдэг байсныг түүхийн баримтууд нотолдог. Түүдэг асаах аргыг бас байлдааны арга мэх болгон хэрэглэдэг ёс ч байжээ.

“Монголын нууц товчоо”-нд Чингисийн их цэрэг Найманыг дарахаар Саарь хээрт хүрч буугаад шөнө амьд хүн бүр таван анги гал түлж сүр бадруулахад Монгол цөөн, морьд нь туранхай хэмээн эрдэж байсан дайснууд нь айж “Монгол цөөн гэсэн биш бил үү? Одноос олон гал ноцож байна” хэмээн сандралдсан тухай

өгүүлдэг бөлгөө. Түүнчлэн хэнгэрэг дэлдэж дохио чимээ өгөх аргыг цэрэг дайны явдалд түгээмэл хэрэглэдэг байсан бөгөөд түүний ул мөр мэдээлэл үсрэнгүй хурдтай хөгжсөн өнөө үед ч байсаар байгаа билээ. Гурван мэргэдийг дайлж өшөө авахад туслахыг гуйж Тэмүүжиний илгээсэн үгийн хариуд Жамух анд:

“Бухын арьсаар бүрсэн

Бүрхирэх дуут хэнгэргээ дэлдэв би...

Үхрийн арьсаар бүрсэн

Өтгөн дуут хэнгэргээ дэлдэв би” хэмээн хэл хүргүүлдэг билээ. Өнөөдөр сургууль соёл, цэрэг армийн дотоодод дун, бүрээ үлээж түргэн хийгээд шугам жагсаалд дуудах, идээ зоогонд урих зэрэг зан үйл хадгалагдсаар байгаа нь хэнгэрэг дэлдэх уламжлалын тод жишээ болох юм. Дохио зангааны мэдээлэл нь зөвхөн чимээ өгөхөөр зогсохгүй, бүр Чингисийн үеэс эхлэн удирдлагын чухал хэрэгсэл болж ирсэн байдаг. Тэр үед төрийн хэрэг, байлдааны явдлыг шуурхай шийдэхэд мэдээлэл чухал байсан нь ойлгомжтой. Чингисийн морьт цэрэг ба тэр үеийн байлдаанд цэргийн үйл ажиллагааг шуурхай удирдахад туг дарцаг, бүрээ хэнгэрэг, далд газарт бол өнгийн утаа зэргээр тодорхой үйлдлийг төлөөлүүлсэн дохио өгч нэгэн төвөөс удирддаг байжээ. Бөөгнөрөөд бутрахдаа ташуурын даллалтаар, бутраад бөөгнөхдөө хэнгэргийн дуугаар дохиолдог

байсан тухай ном зохиолд тэмдэглэсэн бий. Түүнчлэн ав хоморгын үед харилцан дохиолох түлхүүр үйлдлийг энгийн үед сайтар сургуулилж, хүн бүрт эзэмшүүлдэг байжээ.

Дохио мэдээ нь юм үзэгдлийг мэдээлэх, аюул ослоос сэрэмжлүүлэх зэргээр харилцааны үүрэг гүйцэтгэж чаддаг байсан хэдий ч тэдгээрийн учир шалтгаан, шинж чанарын талаар ойлголт өгч бараг чаддаггүй байв. Учир нь тэр эрт цагт хүний сэтгэхүйн үйл ажиллагааг дохио зангаагаар илэрхийлэх боломж нэн хязгаарлагдмал байжээ. Эрт үед энгийн мэдээ занги солилцох хэрэгсэл байгаад, дундад эртний үед хүмүүсийн харилцаанд чухал үүрэг гүйцэтгэх болж, өнөө үед харилцааны төдийгүй ёс журам, зан үйлийн өвөрмөц соёл болж хадгалагдсан дохио зангааг судлах явдал сүүлийн үед эрс өсч байна. Орчин үед дохио зангааг болзмол, болзмол бус, утга нэмэн тодруулах гэж ангилах болсон төдийгүй хэрэглэгдэх хүрээгээр нь зан заншлын, төр ёсны, баяр цэнгэлийн, утга илэрхийлэх байдлаар нь хүндэтгэх дохио зангаа, цээрлэх дохио зангаа хэмээн ялгавартай авч үздэг болсон нь хүн төрөлхтний харилцааны эртний уламжлалт энэ хэлбэр шинжлэх ухааны чухал судлагдахуун болсныг харуулах юм. Доктор С.Дулам: "Монголчуудын язгуур үзэл төсөөллөөр бол утга

учиргүй дохио зангаа, намба намжир гэж огтоос байдаггүй бөгөөд гагцхүү утга учрыг нь үл ойлгох, үл ойшоох л гэж байдаг" гэсэн нь дохио зангааны харилцааны гүн гүнзгий агуулгатайг илтгэхийн хамт түүний учир утгыг түүх соёл, заншилтайгаа холбон судалж, нээн гаргахын чухлыг сануулсан хэрэг байна. Энд дурьдалгүй өнгөрч болмооргүй нэг асуудал бол элэнц үеийн хүний харилцааны анхдагч хэрэгсэл болж байсан дохиж зангаж харилцахын ул мөр шинжлэх ухаан зүйл бүрээр хөгжиж, мэдээлэл-харилцааны техник хэрэгсэл олширсон өнөө үед ч хадгалагдсаар байгаа явдал бөлгөө.



нөө цагт олны дундаас хэн нэгэнд дотночилон хандаж ямар нэг үйл ажиллагаанд уриалан дуудах, ажил төрөл, санаа зорилгоо бусдаас нууцлан хийх буюу хэлэлцэхээр завдах, өндөр барилга болон дуу чимээ ихтэй үйлдвэрт ажиллах мэтэд дохио зангааг хэрэглэсээр байна. Өнөөгийн том хотуудад зорчиж байгаа олон мянган машин тэрэгний хөдөлгөөнийг зохицуулж байдаг гэрлэн дохио ч гэсэн дохио зангаагаар харилцах эртний уламжлалыг шинэ нөхцөлд идэвхүүлэн хэрэглэж байгаагийн бодит жишээ болно.

2. Юм мэдээ. Эртний хүмүүс эд юмс харилцан илгээж, тэдгээрийн утгыг

тайлж харилцдаг байжээ. Түүнийг бид юм мэдээ гэж нэрлэж байна. Ийм харилцаанд утга санаа буюу мэдээллийг зөвхөн эд юмаар төлөөлүүлдэг. Үсэг бичгийн түүх судлаачид мэдээ зангийн оньсого таавар мэт ийм хэлбэрийг юм бичиг, домог буюу үүсгэл бичиг гэх мэтээр нэрлэсэн байдаг. Үнэндээ түүнд үсэг бичгийн гэх шинж тэмдэг бараг үгүй бөгөөд харин учир би-
түүлэг ч гэсэн мэдээ зангийн шинжтэй нь маргаангүй билээ.

Тэдгээр мэргэд, мэдээ занги авалцахад ирээдүйн үсэг бичиг шиг эрхэм соёлыг эрж хайж, элдэв арга чарга хэрэглэж байсан эртний хүмүүсийн эрмэлзлийг баримтлан тийнхүү нэрийдсэн байх гэж бодогдоно. Юмаар харилцахын нэн ойлгомжтой энгийн хэлбэр нь олс дээс мэтийн зүйлд олон зангилаа гаргах, эсвэл утгыг тайлж мэдэхэд зориулсан янз бүрийн хэлбэртэй уяа хүлээ үйлдэх арга байжээ. Ялангуяа өгч, авалцах юмны тоо хэмжээг тохирох, үлдэгдлийг тооцох зэрэгт дээс зангидах аргыг өргөн хэрэглэдэг байсан бололтой.

Юмаар харилцсан тухай домогт гол төлөв улс гүрний хаад ноёд холбогддог

хэдий ч ийм харилцааны эхлэл яавч жирийн иргэд, ухаант мэргэн хүмүүсийн дунд тавигдсан байх ёстой. Ардын оюун билэгтнүүд ухааныхаа хэмжээ царааг сорьж харилцах заншлаас үүдэн дэлгэрч, улмаар улс гүрний дипломат харилцаанд нэвтэрсэн байхыг ч үгүйсгэх аргагүй. Юмаар харилцсан тухай домог хүн нийтийн шинжтэй бөгөөд газар орон

бүрд утга ойролцоо хувилбар болж тархсан байдаг.

Эртний Перс, Скифийн дайны үед скиф нараас Дарий хаанд шувуу, хулгана, мэлхийний хамт таван ширхэг сум илгээснийг Дарий хааны утга тайлагч түшмэл Гобрий гэгч "Та шувуу болж тэнгэрт

халин ниссэн ч, хулгана болж газарт шурган орсон ч, мэлхий шиг усанд шумбасан ч миний сумнаас зайлж чадахгүй" хэмээн тайлсан гэх домог бий. Үүнээс үзэхэд хаад ихэсийн дэргэд тэр мэт далд утгатай мэдээг тайлан уншдаг ухаантнууд байсан нь илэрхий байна.

Эд юмсын утгыг тайлж харилцах арга яваандаа нэлээд хийсвэрлэгдэж, эд юмс илгээхийн оронд харин тэдгээрийн эрхтэн, хэсгийг илгээх аргад шилжсэн нь

«

Юмаар харилцахын нэн ойлгомжтой энгийн хэлбэр нь олс дээс мэтийн зүйлд олон зангилаа гаргах, эсвэл утгыг тайлж мэдэхэд зориулсан янз бүрийн хэлбэртэй уяа хүлээ үйлдэх арга байжээ. Ялангуяа өгч, авалцах юмны тоо хэмжээг тохирох, үлдэгдлийг тооцох зэрэгт дээс зангидах аргыг өргөн хэрэглэдэг байсан бололтой.

»

утга тайлагчдын оюун бодлыг улам бүр дайчлах болсон бизээ.

Монголчуудын дунд дэлгэрсэн нэгэн үлгэрт хил залгаа хоёр улсын хаад нэгэндээ тасын өд, тарваганы хумс, сум, сур бүхий бэлэг илгээж харилцаж байсан тухай өгүүлдэг. Энэ нь яавч тас шувуу, тарвага мэтийг бүтнээр нь тээж явснаас төсөрхөн бөгөөд эд юмсаар санаа бодол, мэдээ занги солилцох арга ухаан ягуухан ч гэсэн дэвшин хөгжиж байсныг нотолж байгаа юм. Юмаар харилцах нь нэг талаар болхи арга мэт боловч, бас нөгөө талаар тухайн үеийн хүний оюун ухаан задран хөгжиж ирсний гэрч гэж үзмээр байдаг.

Эртний хүмүүсийн юмаар харилцаж байсны ул мөр болов уу гэмээр зүйл их хожуу XIII зууны үед зохиогдсон "Монголын нууц товчоо"-нд ч туссан байдаг. Муу хүний хатгалганд орж Тэмүүжинг гомдоосондоо харамссан Ван хан "Одоо хөвгүүнээ үзэж муу сэтгэвэл энэ мэт цусаа урсгая" хэмээн андгайлж байгаагийн илрэл болгож чигчий хурууныхаа өндгийг хутгаар хатгаж, цусыг савируулж аваад өчүүхэн саванд хийж илгээдэг нь юм мэдээний хэлбэртэй байна. Юмаар мэдээлэн харилцах арга нэлээд хожуу үеийг хүртэл хэрэглэгдсээр байсныг гэрчлэх өөр баримтууд ч байна. Бүр ХҮII зууны хоёрдугаар хагаст зохиогдсон

Лувсанданзаны "Алтан товч"-д "Өгэдэй хааны хөл чилээрхэж, Сахьяа бандидыг залж ир гэж элч илгээв. Тэр лам нэгэн бөөс, нэгэн хэсэг шороог нэгэн шарилгуу дотор хийж өгөөд илгээв. Өгэдэй авч үзээд, шороо нь чи үхэх гэсэн байнам. Бөөс өгсөн нь намайг идэхүйдээ одъё гэж байнам. Шарил өгсөн нь хойно Монгол улс номд орох гэсэн байнам" (А. то. 149) гэж тайлсан тухай өгүүлсэн байдаг. Мөн зохиолд өөр нэг сонин баримт байна. Тэр нь: Сахьяа бандидын илгээсэн цутгамал бурхныг Өгэдэй хаан аваад "энэ алт буюу юун хэмээж, хуурайгаар үрснээр эртний буян буурч, гурван хоног чилээрхэн, хаан ор сууснаас арван гуравдугаар он болж, үхэр жил тавин таван насандаа Үдүхү Хуланаа тэнгэр болов" гэжээ. Энэ нь мэдээжээр бурхан шашны хэрэгт буруу хандаж болохгүй гэсэн санаа мөн боловч бас тэр цагт, илгээж харилцсан юмны утгыг зөв таниж, болгоомжтой харьцахыг сургасан мэт ажээ. Хуучин цагийн хиргисүүр, хөшөө чулуу, өнөө үед хэрэглэгдэж байгаа улсын хилийн багана зэрэг нь үнэн чанартаа юм мэдээний ул мөрийг хадгалсан зүйлс юм.

3. Зураг мэдээ. Эртний хүмүүс хад чулуу, агуйн хана туурганд элдэв сүт зураг зурдаг байсан нь мэдээллийн харилцааны эхэн үеийн чухал дурсгал болдог. Тэд санаанаасаа зохиодоггүй

харин амьдралд тохиолдсон, үйлдэж оролцсон, үзэж харсан, эдэлж хэрэглэсэн бүхнээ дүрсэлдэг байсан нь тэдгээр дурсгалыг цаг үеэ тусгасан мэдээлэл байсан гэж үзэхэд хүргэдэг. Тухайн үеийн хүмүүс зургийг хойч үедээ түүх болгон үлдээх гэж зураагүй байх. Харин ахуйгаа л тусгаж байсан нь тэр байх. Хэрэв ингэж үзвэл хадны сүг зургийг мэдээ зангийн зүйл гэж үзэх үндэслэл бүр ч нэмэгдэнэ.

Бидний зураг мэдээ хэмээн нэрлэж байгаа тэдгээр дурсгал ганц нэг амьтан болон багаж мэтийн сүг дүрсээс олон арван дүрсийг нэг доор багтаасан, бас ч утга санаа, үйл хөдлөл илэрхийлсэн зураг болтлоо хөгжсөн байдал илт мэдрэгддэг.

Дэлхийн улс орнуудад хадны сүг зургаар юмс үзэгдлийг мэдээлсэн дурсгал олон байдгийн нэг нь манай улсын Ховд аймгийн нутагт орших Хойт Цэнхэрийн агуйн туурганы зураг юм. Энэ зургийг хуучин чулууны дээд үед амьдарч байсан эртний хүмүүс үлдээжээ. Энэ зургийг 1966 онд Орос-Монголын хамтарсан эрдэм шинжилгээний анги судалсан бөгөөд түүнд арслан, заан зэрэг ан амьтдыг дүрсэлсэн байдлыг академич А.П.Окладников ихэд шагшин магтаж "Ориньяк маягийн" гэж тодорхойлоод умард Испанийн Альте-миро зэрэг дэлхийд алдартай агуйн

зурагтай зүйрлэсэн байдаг. Монгол нутагт байгаа хад чулууны зургуудыг гол төлөв зосоор зурах, хаданд сийлж, ухаж урлах аргаар хийсэн байна. Хойт Цэнхэрийн агуйн зургууд амьтдыг уран зураасаар сонирхолтой дүрсэлсэн байдаг бол Улаанбаатар хотын ойролцоох Гачуурт, Богд хан уулын Их тэнгэрийн ам, Архангай аймгийн Чулуут голын дагуух хүрлийн үеийн олон зураг дурсгалуудад ан амьтан, морь, хүн, нисч яваа шувуу зэргийг дүрсэлсэн нь зохиомж, утга санааны хувьд илүү сонирхолтой юм. Эрдэмтэд өнөө үеийг хүртэл хадны сүг зургийг уран зургийн дурсгал, эртний хүмүүсийн амьдрал, эрхэлдэг аж ахуйг судлах чухал эх сурвалж гэж үзэн, энэ чиглэлээр хийх судалгаанд гол анхаарлаа хандуулж иржээ. Тэгвэл хадны сүг зураг нь бас нийтлэлийн эрт үеийн дурсгал мөн байна. Эртний хүмүүс зөвхөн урлан бүтээх онгод сэтгэлгээндээ хөтлөгдөж тэдгээр сүг дүрсийг зурсан гэдэгт бүрэн итгэх аргагүй. Тэдэнд урлан бүтээхээс өмнө амьдрал ахуйгаа тусгах хэрэгцээ төрсөн байж таарна. Хадны зураг нь ихэнхдээ амьдрал ахуйн тусгал, үзэж харсан зүйлийн мэдээ, бодит байдлын юмс, үзэгдлийг ойлгож ухаарсны үр дүн, хүний санаа бодлын илэрхийлэл байдаг. Энэ шинжээр нь түүнийг "мэдээллийн архив" гэж хэлэхэд төдий л хэтэрсэн

болохгүй байх. Хэрэв түүнд мэдээллийн шинж байхгүй байсан бол эрдэмтэн мэргэд хадны зургийг уншаад "Эртний хүмүүс тийм ийм аж ахуй эрхэлж, тэгж ингэж амьдардаг байжээ" хэмээн баталж нотлохгүй байсан биз. Тэгэхээр хадны зураг нь тэр үедээ амдрал ахуйг тусгасан мэдээ байсан шигээ, өнөөдөр ч өнө эртний явдлыг бидэнд мэдээлж байгаа мөнх настай мэдээлэл юм.

Дээр өгүүлсэн Хойт Цэнхэрийн агуйн зураг нь ан гөрөөс, мал, элдэв хэлбэрийн тэмдэг гэсэн гурван хэлбэрээс бүтдэг байна. Эртний хүмүүс агуйн хананд адгуусан амьтдыг зурахдаа нэгэн дэвсгэр дээр олон төрлийн амьтныг багтааж, заримыг хагас бүтэн биеэр зөрөлдүүлэн дүрсэлсэн нь Монголын палеолитийн үеийн хүмүүс оюун ухааны хувьд ихээхэн хөгжиж, юмс үзэгдлийг дүрслэхдээ хийсвэрлэх, төлөөлүүлэх аргыг хэрэглэдэг болсны баримт гэж эрдэмтэд үздэг. Хадны зураг судлаач Т.Санжмятав Гурван Цэнхэрийн голын агуйн зурагт зэрлэг тэмээ, мод хоёрыг нэг дор дүрсэлсэн арга барил нь адгуусан амьтан, байгаль хоёр салшгүй холбоотой гэсэн эртний хүмүүсийн ойлголтыг урлагийн аргаар чадварлаг дүрсэлсний гэрч болохыг дурьдаад "Тус агуйн хананд буй арслан заан, тэмээн хяруул, аргаль зэрэг амьтны дэргэд дугариг буюу зууван толбо зурж ямар нэг

утга санааг илэрхийлсэн тэмдэг болгосон байдаг. Ийм толбон тэмдгийг тавихдаа уг амьтдыг олон дахин зурахгүй зөвхөн толбо, янз бүрийн тэмдэг төдийгөөр төлөөлүүлэн зурсан, бас уг амьтдыг хэд хичнээн болохыг оруулсан тооны илэрхийлэл байж болно" гэсэн таамаг дэвшүүлсэн байдаг. Үүний зэрэгцээ бас мэдээллийг илүү хялбар аргаар хийсвэрлэн хүргэх гэсэн санаа, өөрөөр хэлбэл зургаар мэдээлэх арга ухаан нарийсан боловсорч байсны нотолгоо гэж үзэх үндэс байна.

Хадны зурагт тухайн газарт ан гөрөөс байгааг ч юмуу, эсвэл түүнийг агнасан тухай гэх мэтийг мэдээлдэг бол, агуйд амьдрагчид ам бүлийнхээ хүний тоо, язгуур овгоо илтгэхийн тулд алганыхаа хээг агуйн хананд үлдээдэг байсан гэж зарим хүн үздэг. Ийм шууд мэдээлэл цааш хөгжин аль нэг газар орон хийгээд бусад зүйлийг эзэрхсэнийг гарын зургаар, гол мөрөн гаталсныг хөлийн зургаар гэхчилэн нэлээд хийсвэрлэн мэдээлдэг болсон гэж үзэх явдал ч бий. Ямартай ч эртний чулуун зэвсгийн үед Монгол нутаг дээр тухайн үедээ харьцангуй боловсорсон овог аймгийн хүмүүс аж төрж, ахуй амьлдралаа дүрслэн мэдээлж байсныг баттай мэдэж болдог.

Хадны зурагт эртний хүмүүсийн эд өглөгийн зүйлс, багаж зэвсгийн хөгжил,

амьдрах арга ухааны ахиц дэвшлийн тухай арвин мэдээлэл агуулагдаж байдаг. Эрт үедээ араатан жигүүртэн, аргаль янгир дүрсэлдэг байснаа, хутга мэс, нум сум, улмаар газар тариалан, мал аж ахуйн сэдэв тусгагдах болжээ. Хүнд элдэв загварын малгай, өмд гутал өмсгөж, бүс бүслүүлэн зурсан нь олон.

Түүнчлэн үхэр адуунд тэрэг хөллөсөн, дэргэд нь зогсон, дээр нь суусан байдалтай зураг ч элбэг бий. Эхлээд зосоор болхидуу дүрсэлдэг байснаа хүрлийн үед амьтан, юмсын төрх байдлыг нэлээд тод гаргаж, аливаа үйл хөдлөлийг чадмаг илэрхийлэх болжээ.

Ийнхүү хүн ахуй орчин, ажил үйлстэй холбогдож эхэлсэн нь тэдгээр зургийн мэдээллийн багтаамжийг нэмэгдүүлж байв. Тухайлбал хүнийг гэхэд л алхаж, гүйж байгаа, зэр зэвсэг барин ан гөрөө хийж байгаа, мал, газар тариалан эрхэлж байгаа, хөсөг тэрэг ашиглаж байгаа байдалтайгаар дүрслэх болжээ. Түүгээр ч зогсохгүй хүнийг айж зугатсан, гэтэж мяраасан, ажиглан шинжсэн, баярлаж хөөрсөн, бүжиглэн цэнгэсэн,

биширч шүтсэн гэх мэтээр дүрсэлж, сэтгэлийн хөдөлгөөнийг илэрхийлэх болсон нь нэг талаар тэдгээр зураачдын урлах арга барилын өсөлтийг харуулах боловч, нөгөө талаар эзэмшсэн арга бололцооныхоо хэрээр үзэгдэл, үйл явдлыг аль болох тодорхой илэрхийлэхийн зэрэгцээ, зохиогчийн дотоод сэтгэл,

үзэл санаа илэрч байгаа нь ирээдүйн бичмэл нийтлэлийн сэтгэлгээний үр бүрэлдэж байсныг харуулдаг.

Хадны зурагт эртний хүмүүсийн хоорондын тэмцэл, ан гөрөө, мал амьтан, эмс охидыг булаалдсан тухай сэдэв

элбэг байдаг. Тэдгээр зургуудад хүний амьдралын жам ёс, танин мэдэхүйн санааг илэрхийлсэн байх нь олонтаа үзэгдэнэ. Овгийн байгууллын үед эх хүнийг их дүрсэлдэг байснаа аажимдаа тэдгээрээс үр хүүхдээ төрүүлж, өсгөж байгаа хийгээд эр хүнтэй энгэр зөрүүлж буйг ч дүрсэлдэг болжээ. Хүн болоод байгалийн харилцан хамаарал, тэр ч байтугай газар дэлхий, гариг эрхсийн зүй тогтлыг мэдэж, эзэмдэхийг мөрөөдсөн

«

Хүнийг айж зугатсан, гэтэж мяраасан, ажиглан шинжсэн, баярлаж хөөрсөн, бүжиглэн цэнгэсэн, биширч шүтсэн гэх мэтээр дүрсэлж, сэтгэлийн хөдөлгөөнийг илэрхийлэх болсон нь нэг талаар тэдгээр зураачдын урлах арга барилын өсөлтийг харуулах боловч, нөгөө талаар зохиогчийн дотоод сэтгэл, үзэл санаа илэрч байгаа нь ирээдүйн бичмэл нийтлэлийн сэтгэлгээний үр бүрэлдэж байсныг харуулдаг.

»

шинжтэй зургууд ч байдаг. Тухайлбал хүнийг нарны дэргэд байгаагаар, эсвэл хоёр гарын оронд далавчтай зурсан зэрэг нь эрдэмтдийн сонирхлыг аргагүй татдаг байна.

Эртний хүмүүс хэдийгээр байгалийн сүр хүчний өмнө чадал мөхөсддөг байсан ч хүрээлэн байгаа орчин, эд юмс, адгуусан амьтан бүгдийг эзэмдэн захирч, үйлдвэрлэн бүтээх хувь тавилантайгаа ямар нэгэн хэмжээгээр ойлгож, хүсч мөрөөдөж байсныг харуулж чаддаг хадны сүг зургийн үнэт чанар оршдог билээ. Нийтлэл зүйн үүднээс авч үзвэл тэдгээр зургууд нь цөм ахуй амьдрал, цаг үеэ тусгасан мэдээлэл юм. Тэхдээ юмс үзэгдлийн хамгийн энгийн бөгөөд бодит тусгал байв. Тэдгээр зургийн ур дүй, утга санаа үеэс үед боловсрон хөгжихийн хэрээр мэдээлэх арга бололцоо нэмэгдэж байсан нь лавтай. Энэ бүхэн нь тэдгээр дурсгалыг зураг мэдээ гэж үзэх үндэс болж байгаа юм. Бичиг үүссэн хойно ч гэсэн чухал үйл явдал, мэдээллийг хад чулуунд бичиж сийлэх явдал байсаар байжээ. Энэ тухай "Лу. Алтан товч"-д "Дээд тэнгэрээс заяагаар, чин зоригт чандмань мэт богд Чингис хаан төрөх, хамгийг мэдэгч тэр болох буй" хэмээсэн Сахьяагийн Гунгаа Нямбуу ламын зарлигийг Хятадын Илишида Шигу, Би Ба нэрт хоёр хүнээр Бурхан Халдунаа улаан чулуунаа

цавчиж бичүүлэв" (20 дахь тал) гэж тэмдэглэсэн ажгуу. Эрт цагийн зураг мэдээний үлэмж боловсронгуй хэлбэрийг өнөөдөр ч ашиглаж байгаа юм. Тухайлбал авто хөсгийн хөдөлгөөнийг зохицуулж байдаг замын дагуух хэвтээ буюу босоо тэмдэглэгээ, цаг агаарын үзэгдлийн тэмдэг зэргийг нэрлэж болох юм. Өндөр хүчдэл, аюул осолтой газар, зуудаг нохойноос сэрэмжлүүлэх зорилгоор тусгай тэмдэг зурж мэдээлэх ёс ч бий.

4. Тамга мэдээ. Эртний хүмүүс угсаа гарваль, газар нутаг, өмч хөрөнгөө ялган таниж, эзэмших эрхээ баталгаажуулахдаа им, тамгыг хэрэглэж эхэлжээ. Өөрөөр хэлбэл им, тамга нь тухайн цагтаа нийгмийн харилцааны хэм хэмжээг зохицуулдаг нэг янзын мэдээлэл байсан байна. Им, тамгыг цаг хугацаа, зорилгын хувьд нь овгийн, өмчийн гэж ангилдаг.

Хүн сүргийн үеийн дараа эхийн эрхт ёс үүсэхийн сацуу овог аймгийн дотоод хөдөлмөрийн хувьаарь үүсч, бүтээгдэхүүн солилцох болсноор овгийн тэмдгийн эхлэл тавигдсан бололтой. Тэр цагт хүмүүс амьдрахын эрхээр тархан нутаглах болсон нь овгийн хүн бүлийг ялгаж таних тамга тэмдэг үүсэхэд нөлөөлсөн байна.

Им, тамгыг анх овгийн хүн бүл тусдаа буюу нийтээр хэрэглэх багаж

зэвсэг, сав суулган дээр дардаг байжээ. Хожим төмөрлөг зэвсэг, эдлэл хэрэглэн, адгуусан амьтдыг гэршүүлж, мал аж ахуй эрхлэх болсонтой уялдан им, тамганы тоо олширч, мал адгуусанд улайсгасан хэвээр тамга хайрах болсон байна. Овгууд шинээр салбарлах тутам хуучин эх тамганы дүрсэнд нэмэлт зүүлт хийж үүсгэмэл тамга гаргах, шинээр үйлдэх зэргээр тамганы тоо, хэлбэр дүрс олширчээ. Үүнтэй нэгэн адил тамга дарах хэрэгцээ шаардлага ч нэмэгдсэн байна.

Олон овгийн их хуралдайд очихоор явсны гэрч баримтыг хоцроох, нийтээр ашиглах ус бэлчээрийг эзэмших эрх, хил заагийг бататгах зэрэг зорилгоор тухайн газар орны нэр цуутай хад цохион дээр овгийн тамгаа сийлдэг байв. Энэ нь түүхэн үйл явдлыг гэрчлэх, нийгмийн харилцааг зохицуулахад чиглэсэн чухал мэдээлэл байв. Овог аймгийн тамга нь Монгол нутагт амьдран суусан эртний овог аймгууд удам угсаа, үүсэл гарвацийн хувьд үе үед нэгэн адил байгаагүй, нийлж ижилссэн, салж ондоошсон, холилдон нутагшсан, холчлон нүүдэллэсэн байдал төлөвийг хойч үед хоцроосон чухал дурсгал төдийгүй тухайн үедээ онцгой үүрэгтэй мэдээлэл байжээ. Үүнтэй холбогдуулан түүхч Х.Пэрлээ авгай "Овог аймгийн тамгаар

эртний ба дундад үеийн олон Монгол аймгийг газар нутгийн талаар хайж болохоос гадна тэдний хүн амын багцаа тоо, бүрэлдэхүүний ирмэл, суумал алин болохыг мэдэж, мөн тэд дэлхийн аль газар орон, аймаг угсаатантай ямар ямар зүйлээр хэлхэлдэн сүлбэлдсэнийг ч зөв таамаглаж болох юм" хэмээсэн байдаг бөлгөө. Тэрбээр Хэнтий аймгийн Биндэр уулын Рашаан хад, түүний орчмоос нийтдээ 400 гаруй тамган дүрс, амьтны сүг зураг олсон нь тамганы үүсэл, төрөл, хэлбэр, зориулалтыг нарийвчлан судлах явцыг урагш давшуулж билээ.

Монголчуудын овгийн тамга нь хожуу үеийн өрхийн малын тамганд уламжлагдсан байна. Эрт цагаас мал аж ахуй эрхэлж ирсэн монголчуудын хувьд малын им, тамга нь үйлдвэрлэлийн харилцааны хийгээд мэдээллийн чухал хэрэгсэл болж иржээ. Иймээс монгол айлын мал үе залгамжилсан үндсэн тамгатай байхын зэрэгцээ түр тэмдэг тавьдаг ёс байсаар ирсэн билээ. Тэр нь малын баас, зосноос гадна үсийг хайчлан элдэв дүрс гаргах, сүүлний үсийг танах, хялгас ноосыг сүлжиж зангидах, хүзүү болон сүүлэнд нь юм зүүх, пайз уях зэрэг хэлбэртэй байв.

Им бол тамганаас түрүүнд, бүр манай эриний өмнөх үед үүссэн бөгөөд овгийн нэн эртний тэмдгийн үлдэц юм.

Имийг анхандаа өөр өөр овгийн хүмүүсийг ялгах зорилгоор хэрэглэж байгаад хожим малд хэрэглэдэг болсон ажээ. Имийг хүнд хэрэглэдэг байсны хожуу үеийн баримтыг Хавт Хасар ноёны боол нь "Сарьсан гуяндаа тамгатай, саримгар чихэндээ имтэй" гэснээс мэдэж болно. Хувилай сэцэн хаанаас эхлэн Монголын хаадууд Хятадын Дайду хотод нэг зуун таван жил зургаан сар нийслэллэж байсны сүүлчийнх нь болох Ухаант хааныг тэнгэрт халихад хятад гаралт Хон Хуа хаан сууринд сууж, Хонгирад хатныг нь эзэлсэн ажээ. Эцгийгээ халихад гэдсэнд гурван сартай байсан хүү Юнлу хожим хаан болоод Хон Хуагийн хүү Загуяаг барьж "хүзүүнд нь мөнгөн тамга дарж" үлдээж орхисон тухай Лувсанданзаны "Алтан товч"-д (156-р тал) өгүүлсэн байдаг. Бүр хожим Манжийн ноёрхлын үед "Сайн эрс", "Муу хулгай" гэгдэгч ардын тэмцэгчдийн нүүрэнд "Ялтан" хэмээх үг үсэг шивдэг байсныг түүх шастирт тэмдэглэн үлдээжээ.

Монголчуудын нийгмийн хийгээд үйлдвэрлэлийн харилцааг зохицуулж байсан дүрст мэдээллийг им, тамга, тэмдэг хэмээн, ялгадаг бөгөөд малын чихийг хайчилж янз бүрийн ором гаргахыг им гэнэ. Ноёдын сүргийг ялгамжлах тэмдгийг тамга, харин албат, шавь, хамжлага ардын малыг таниулах

дүрсийг тэмдэг хэмээн нэрийдэх журамтай байжээ.

Нийгмийн амьдралын үндэс суурь, гол арга болж ирсэн мал маллах арга ухаан, түүний дотор им, тамганы түүх эрдэмтдийн анхаарлыг татсаар иржээ. Өнгөрсөн хугацаанд академич Б.Ринчен 1954 онд Чехословакийн "Архив Ориентални" сэтгүүлийн 22 дахь дугаарт хэвлүүлсэн "Монголчуудын өмчийн тэмдэг" гэдэг өгүүлэлдээ малын тамганы 200 гаруй дүрсийг зурж, нэрсийг хадсан бол, угсаатны зүйч Ц.Гочоо 1958 онд "Шинжлэх ухаан, техник" сэтгүүлийн 4 дүгээрт нийтлүүлсэн "Малын им, тамганы тухай" гэдэг өгүүлэлдээ малчдын хэрэглэж байгаа болон улсын архивт буй Халхын зарим хошуудын алдуулын дансанд тэмдэглэгдсэн малын тамганы дүрс зэргээс 360 дүрс цуглуулснаа жагсаажээ. Түүнчлэн Чой.Лувсанжав, Р.Дорждагва, Б.Цэрэл нарын олон хүн малын им, тамга судалж эрдэм шинжилгээний өгүүлэл бичигцгээжээ. Хуульч Д.Чойсамба "Малын им, тамга, түүний хууль цаазын ач холбогдол" гэдэг номондоо малын им, тамганы үүсэл, хөгжлийн тухай товч өгүүлж, тамганы 300 гаруй дүрс, имийн 26 дүрсийг цуглуулсан байдаг. Эдгээрээс үзвэл манай ард түмэн им тамганы баялаг хэлбэрийг буй болгож, түүгээрээ

дамжуулан малынхаа тухай мэдээлэл авдаг байжээ. Малын им, тамга нь сүрэг малыг алдаж үрэгдүүлэх, сольж холих, булааж дээрэмдэхээс сэрэмжилсэн тэмдэг, хаанахын хэний алдуул болохыг гэрчлэх нэг ёсны баримт, мэдээлэл болж ирсэн байна.

Монголын феодалын байгуулал буюу эзэн, харьяатын ёс хөгжих тутам малын тамганы зүйл нэмэгдэж жирийн өрхийн малын тамга, эзэн ноёны сүргийн тамганаас гадна Манжийн болон Халхын засаг захиргааны албан сүргийн, жас жавын, хутагт хувилгаадын, хожмоо Хятад, Оросын худалдаачдын малын тамга гэх мэт олон ялгаатай

болжээ. Тэдгээр олон тамга тэмдэгт хуучин овгийн тамганы уламжлалт дүрсийг ашиглахын зэрэгцээ, түүний дээр, дотор, дэргэд монгол, төвд, энэтхэг, нангиад үсэг, тоо нэмэх, заримдаа дан үг, үсгээр тамга бүтээх заншил дэлгэрсэн байна.

Энэ нь нийгмийн анги бүлгийн хооронд, эгэл ардын хооронд мал аж ахуй эрхлэх харилцааг журамлаж, өмч хөрөнгийг ялган салгах, эзэмших эрхийг

баталгаажуулахад чухал үүрэгтэй мэдээллийн харилцааны нэг янзын хэрэгсэл байсан юм. Малын им, тамга нь мал маллагааны хамааралтай сураг занги солилцох онцгой мэдээлэл байсан, байсаар ч байна. Манай малчин ардууд малын эрэлд явах, сураг тавихдаа им, тамгыг онцлон дурьдаж, үзсэн харснаа мэдээлэхэд ч түүнийг гол баримт бол-

годог нь малчин түмний харилцаанд им, тамга ямар их үүрэгтэй мэдээлэл болохыг харуулах бэлэн жишээ мөн.

5. Ам мэдээ.

Хүн төрөлхтөн үг хэлээр харилцдаг болсон нь мэдээ занги солилцох явдалд гарсан том хувьсгал мөн. Үг хэл нь сураг

занги солилцох үр дүнтэй арга болохын зэрэгцээ хүний танин мэдэхүйн үйл явц, сэтгэхүйн хөгжилд асар их үсрэлт гаргажээ.

Үг хэл үүссэнээр хүмүүсийн харилцаа илүү боловсронгуй болж, зөвхөн юмс, үзэгдлийг заах төдий мэдээллээс хүний дотоод сэтгэлийн нарийн мэдрэмжийг илэрхийлэх шинэ шатанд дэвшсэн нь мэдээллийн агуулгыг баяжуулахад хүчтэй нөлөөлсөн байна.

«

Монголын феодалын байгуулал буюу эзэн, харьяатын ёс хөгжих тутам малын тамганы зүйл нэмэгдэж жирийн өрхийн малын тамга, эзэн ноёны сүргийн тамганаас гадна Манжийн болон Халхын засаг захиргааны албан сүргийн, жас жавын, хутагт хувилгаадын, Хятад, Оросын худалдаачдын малын тамга гэх мэт олон ялгаатай болжээ.

»

Хүний харилцааны анхдагч шалтгаан нь мэдээлэх хэрэгцээ байсан нь тодорхой юм. Хэл яриа үүссэнээр хүн урьдын адил дохиж зангахгүйгээр харилцан мэдээлэх хэрэгцээгээ зөвхөн амаар хангах бололцоо нээгджээ. Ярилцана гэдэг бол эцсийн дүндээ мэдээ солилцох замаар ямар нэг асуудлыг харилцан ойлголцож байгаа хэрэг. Ингэхээр ярьсан бүхэн мэдээ мөн гэж үзэхэд хүргэнэ. Ам мэдээ гэж томъёолохын учир ч үүнд орших амой.

Хүн төрөлхтөн үг хэлээр харилцах болсны үнэ цэн, ач холбогдлыг нэг удааны оролдлогоор бүрэн дүүрэн илэрхийлэхэд бэрх юм. Үүнийг зөвхөн үг хэл үүсээгүй байх үед хүмүүсийн харилцаанд ямар их гачаал тулгарч, санаагаа илчлэх гэж яаж зүдэрдэг байсныг төсөөлөн бодоход л хангалттай юм. Нөгөө талаар үг хэл үүссэнээр хүний харилцаа асар их өргөжиж, танин мэдэхүйн өргөн бололцоо нээгдсэн байна.

Дохио зангаа, эд юмсаар харилцахад зөвхөн тухайн юм, үзэгдлийн талаар тойм төдий ойлголт авдаг байсан бол хэл яриа нь хүмүүс санаа бодлоо төвөг бэрхшээлгүй дамжуулахын зэрэгцээ өнгөрсөн, одоо, ирээдүй гурван цагийн явдлыг нэгэн цагт хураан мэдэж болдоороо онцгой юм. Хэл яриа үүсэнгүүтээ л бүхнийг тэмдэглэн ойлголцоход

хүрэлцэж байсан уу гэвэл үгүй байх. Нийгмийн хөгжлийн явцад хэлний үгсийн сан арвижиж, ямар ч нарийн төвөгтэй ойлголт, утга санааг илэрхийлэхэд хүрэлцэхүйц нөөцтэй болсон нь жам ёсны доторх хэрэг биз ээ.

Хэл ярианы бас нэг онцлог нь харилцагч хоёр этгээд нэг дор байх үед л мэдээлэл солилцох хэрэглүүр болж чаддагт оршино. Түүнчлэн амаар уламжлах мэдээллийг алсад хүргэх дуу хоолой хязгаартай. Энэ дутагдлыг нөхөх аргыг хүмүүс аль эрт хайж олоод, хаа сайгүй хэрэглэдэг байжээ. Энэ тухай ном зохиолд тэмдэглэснийг үзвэл "Эртний хүмүүс үг хэлээр сураг занги солилцоходоо хөндлөнгөөр буюу гулдаар уламжлах хоёр зүйлийн аргыг хэрэглэдэг байжээ. Хөндлөнгөөр сураг занги уламжлах гэдэг нь нэг нь аравд, арав нь зууд дамжуулан уламжлахыг хэлдэг. Гулдаар сураг занги уламжлах гэдэг нь нэг үе нь нөгөө үедээ дорогш тасралтгүй дамжуулан уламжлахыг хэлдэг байжээ". Энэ арга нь үг хэлний хоёр зүйлийн дутагдлыг нөхдөг байсан бөлгөө. Нэгд: үг хэл нь утга илэрхийлэхийн тухайтад гайхамшигтай хэрэгсэл боловч хүний дуу тархах хязгаартай тул хөндлөнгөөр уламжлах замаар мэдээллийг аль болох олон хүнд хүргэж, уудам орон зайд тархаадаг байв. Хоёрт: үсэг бичиг үүсээгүй байсан үед мэдээллийг хойч үедээ

өвлүүлэн хоцрооход гулдаар уламжлах арга зохистой байжээ.

Харилцаа-мэдээллийн хүчирхэг хэрэглүүр болох хэл үүссэн нь хүний нийгмийн урт удаан хугацааны хөгжлийн үр дүн юм. Хэл анхандаа дэлхийн нэг буюу хэсэг газарт үүсч, амьдрах арга, хөдөлмөрийн хуваарь нарийсахын хэрээр хүмүүс газар нутаг тэлж, тархан суурьших үед газар газрын хэл салбарлан үүссэн байна. Тэр мэтчилэнгээр өнөөдөр дэлхий дахины хүн үүсэл гарлаараа харьцангуй ойролцоо хориод овогт багтах 3000 орчим хэлээр харилцдаг болсон ажээ.

Анхны хүй нэгдлийн нөхцөлд хүмүүс хамт олноороо хөдөлмөрлөж, нийгмээрээ амьдардаг болсны улмаас хоорондоо харилцан саналаа солилцох зайлшгүй хэрэгцээ гарсан байна. Тэр хэрэгцээ нь хүний тархинд үг хэлийг удирдах төвийг бий болгосноор барахгүй, түүнд тохирсон үзүүр хязгаарын буюу өгүүлэх эрхтнийг аажмаар бий болгосноор үе гишүүт үг хэл үүссэн билээ. Үг хэл нь хүмүүсийн харилцаа, хөдөлмөрийн явцыг зохион байгуулахад асар их учир холбогдолтой, ач тустай зүйл байв. Жишээлбэл хүй нэгдлийн зэрлэг бүдүүлэг хүмүүс нүхэнд унасан том араатныг аюулгүй агнах арга хайж сандарч байтал хэн нэг нь гэнэт "Чулуу!" хэмээн хашгирчээ гэж бодъё. Түүний

хашгиран заасан том чулуугаар шидлэн, араатны биед хүрэлгүйгээр аюулгүй агнаж чадлаа гэж санавал аргагүй хэрэгцээ тулгарсан үед гарсан мөнөөх "Чулуу" гэсэн ганц үг хичнээн их тус болж байгааг мэдэрч, үгийн ид шидийг бишрэн, цаашид шинэ шинэ үгийг үүсгэн хэрэглэсээр хэл үүссэн байж таарна.

Тэр бүхний дундаас Монгол хэл яриа үүссэн он цагийг нарийн тогтоох боломжгүй ч нэн эрт язгуур цагт холбогдоно гэдэгтэй эрдэмтэд санал нийлдэг. Тэд Монгол хэлний хөгжлийг эртний, дундад үеийн, орчин үеийн монгол хэл гэж гурав ангилдаг. Эртний монгол хэл нь мэдээжээр дээр дурьдсан нэн эртний язгуур цагаас манай эриний бараг VIII зуун хүртлэх үеийг хамрах бөгөөд тэр хэлний дурсгал нэн ховор юм. Тухайн цагт хөрш зэргэлдээ оршин сууж байсан ард түмнүүдийн түүхэн сурвалж, ялангуяа хятад үсгээр дуудлагыг нь галиглан тэмдэглэсэн хэрэглэгдэхүүн мэр сэр олджээ. Мөн сяньби хэлний нэг аялгуу болох табгач хэлний дурсгалаас эртний монгол хэлний онцлогийн талаар эрдэмтэд зарим нэг зүйлийг олж мэдсээр байна.

Мэдээллийг үг хэлээр уламжлах болсон нь хүний хөгжил харьцангуй өндөр түвшинд хүрсний илрэл юм. Хэл үүссэнээр юуны өмнө сэтгэхүйн хөгжлийг үлэмж давшуулсан байх ёстой. Үг

хэлээр дамжин хүмүүс мэдлэг туршлагаа уламжилж, ажил үйлсийн арга ухаан, хорвоо ертөнцийн юмс үзэгдлийн талаар шинэ мэдлэг, мэдээллийг бусдаас олж мэдэх болсон нь лавтай. Ингэснээр хүний үзэл бодол, ухамсар аажмаар төлөвшиж эхэлсэн байж таарна. Нөгөө талаар хүний аж төрөлд шинэ зүйл нэвтэрч, мэдлэг туршлага арвижих тутам хэлний хөгжлийг урагш ахиулж, үгсийн сан баяжин, үгээр утга илэрхийлэх ур маяг аажмаар боловсрон хөгжсөн байна. Үүнтэй холбоотойгоор үг хэлээр зөвхөн харилцах төдий бус үзэл бодол, мэдлэг туршлагаа бусдад уламжлах, өөрөөр хэлбэл мэдээлэл түгээх зориудын үйл ажиллагааны анхны хэлбэр буй болсон нь ам мэдээ мөн.

Ам мэдээ цаашид улам төгөлдөржсөөр үйл явдлыг зөвхөн мэдээлэх бус тэдгээрийн шинж чанар, агуулгыг нээж, хүнд хүрч нөлөөлөхүйц сонирхолтой бүтэц, зохиомж бүхий болсон байна. Ам мэдээний хөгжлийн үр дүн нь ардын аман зохиолын олон хэлбэр - үлгэр, тууль, домог, ерөөл, магтаал, дуу, зүйр, цэцэн үг, оньсого, сургаал үг, хууч яриа мөн гэж үзэх үндэс бий. Өнөөгийн бичмэл нийтлэлийн хөрс суурь болсон аман нийтлэл, илтгэл яриа ч мөн л үг хэлээр хийх мэдээллийн үлэмж төгөлдөржсөн дээд хэлбэрүүд мөн.

6. Элч мэдээ. Эрт цагт алс газарт мэдээ занги дамжуулах бараг цорын ганц хэрэгсэл нь хүн өөрөө байжээ. Эд юмсаар харилцдаг байх цагаас эхлээд бичиг захидал илгээх болсон үед ч хүн л түүнийг хүргэдэг байсан аж. Хүнээр мэдээ занги хүргүүлэх нь хоёр янз байсан бололтой. Нэг нь ямар нэг эд юмс, эсвэл захидлыг зохих эзэнд нь хүргэж өгөх, нөгөө нь хүн өөрөө мэдээ болох явдал мөн. Бүр хожуу үед буюу үсэг бичигтэй болсны дараа ч элч мэдээ чухал үүрэгтэй байжээ. Ялангуяа дайн самуунтай, цаг төр тайван бус нөхцөлд элч мэдээг илүү найдвартай гэж үздэг байсан бөгөөд замд олзлогдоход хүрвэл бичиг захиа, бусад эд мөрийн баримт олдохгүй, хэл мэдээ зөвхөн элчтэй хамт дуусдаг байжээ. Ийнхүү элчээр мэдээ дамжуулахыг монголчууд "Дуу бариулах" гэдэг байв. Энэ нь мэдээ чимээ зөвхөн элчийн дуу хоолойгоор дамжих учрыг илтгэх бөгөөд хүргэх мэдээнийхээ агуулгыг гүн утга, яруу сонсголон бүхий шүлгийн хэлбэрт оруулаад элчид ягштал цээжлүүлсний дараа илгээдэг байжээ. Үүнийг Чингис хаан Сэнгүм андад хэлүүлсэн үгэндээ: "Би эцгийн дээлтэй төрсөн хөвүүн ажээ. Чи нүцгэн төрсөн хөвүүн ажээ. Хан эцэг бид хоёрыг нэгэн адил асардаг. Үүнд Сэнгүм чи атаархан завсардуулж намайг хөөлгөв. Одоо чи, хан эцгийн элгийг эмгэнүүлэхгүй, зүрхийг

зүдүүлэхгүй, өглөө үдэш орж гарч санааг баясган, сэтгэлийг сэргээж яв. Чи эртний санаснаа үл тавин, хан эцгийг амьд байтал хан болох гэж эцгийн сэтгэлийг битгий зовоо" гэж Архай Хасар, Сүхэхай жэүн хоёрт энэ үгсийг цээжлүүлж илгээв" ("Нууц товчоо". 181-р зүйл) гэсэн мэдээ болон бусад олон баримтаас тодорхой мэдэж болно. Элч нь эзэндээ үнэнч,

ямар ч үед нууц задруулахааргүй найдвартай хүн байх ёстой байсан нь мэдээжийн хэрэг. Энэ тухай эртний Сүн улсын цэргийн жанжин Хун Мин гэгч XIII зууны хориод оны үед Монгол газарт зорчсон тухай тэмдэглэлдээ "Эзэн нь ямар нэг тушаал буулгах, гэрээ хэлцэл хийхдээ зөвхөн элч

илгээдэг. Харин илгээсэн зүйлээ мартагчийн тулд болхи тэмдэглэгээ хийдэг байв. Элч нь дамжуулсан үгийг ганц ч үгийн зөрөөгүй илтгэдэг бөгөөд энэ нь тэдний том уламжлал юм" гэсэн байдаг.

Элчид зөвхөн зурвас, пайз, ямар нэг таних тэмдэг өгч явуулдаг байсан нь өөрийн элч мөн болохыг батлах зорилготой байжээ. Энэ санаагаа бүр баримтжуулж "гэрэгэ" хэмээх алт, мөнгөн пайз

өгч явуулдаг ёс ч байжээ. Хэрэв зурвас дагалдуулахад хүрвэл "Хэлэх үг элчийн аманд" гэсэн үг бичдэг байв.

Элч илгээж мэдээ занги авалцах нь монголчуудын хувьд, ялангуяа төрийн чухал хэрэг явдалд өргөн хэрэглэгддэг байсныг батлах баримт түүх шаштирт элбэг үзэгддэг билээ. Ганц нэгийг дурьдвал, Лувсанданзаны "Алтан товч"-д

«

Сүн улсын цэргийн жанжин Хун Мин гэгч XIII зууны хориод оны үед Монгол газарт зорчсон тухай тэмдэглэлдээ "Эзэн нь ямар нэг тушаал буулгах, гэрээ хэлцэл хийхдээ зөвхөн элч илгээдэг. Харин илгээсэн зүйлээ мартагчийн тулд болхи тэмдэглэгээ хийдэг байв. Элч нь дамжуулсан үгийг ганц ч үгийн зөрөөгүй илтгэдэг бөгөөд энэ нь тэдний том уламжлал юм" гэсэн байдаг.

»

"Чингис хааныг хаан болгов хэмээн Хэрэйдийн Тоорил хаанд Тахай, Сүгэй хоёр элчийг илгээв" гэсэн мэдээ байх бөгөөд Тоорил хаан түүний хариуд:

"Энэ эеэ бүү эвдэгтүн

Эе зангиа бүү тайлагтун

Эх захаа бүү алдагтун" гэсэн за-

хиасыг элчид хэлж илгээсэн гэж өгүүлдэг.

Мэдээлэл харилцаа, шуудан тээвэр хөгжөөгүй байсан XIII зууны үед элч нь мэдээллийг өөрийн биеэр тээж, өөрийн үгээр дамжуулдаг нэг ёсны хэрэгслийн үүрэг гүйцэтгэдэг байв. Тиймээс ч Эзэн Чингисийн "Их засаг" хуулинд элч төлөөлөгчийн аюулгүй байдлыг баталгаажуулж "Элч зарлагыг гутаан дором-

жилж үл болно" гэж заасан байдаг. Чингис хаан хуулийнхаа энэ заалтыг хэрэгжүүлэхийг эрхэм дээд үүрэг гэж үздэг байсан нь дайн дажинтай тэр цагт төрийн хэрэгт элчийн үүрэг асар их байсантай холбоотой юм. Тиймээс ч Чингис хаан өөрийнх нь илгээсэн 400 гаруй хүний бүрэлдэхүүнтэй элчдийг хүйс тэмтэрсний хариуд Хорезм улсад дайн зарлаж, цээрлэл үзүүлсэн түүхтэй. Нөгөө талаар элч зарлага нь зөвхөн хэл мэдээ залгуулагч төдий бус Эзэн хааны болон төрийн төлөөлөгч, өнөөгийн жишгээр бол элчин сайдтай эн зэрэгцэхүйц үүрэгтэй хүн байв. Тэр тусмаа "таван өнгө, дөрвөн харь улсаас эхлэн Замбутивийн гурван зуун жаран нэгэн омогтон, долоон зуун хорин хэлтэн улсын алба гувчуур авч, гар газар, хөл хөсөр амаржуулж, Заграварди хаан мэт алдаршсан" (Лу.Алтан товч. 20 дахь тал) Дэлхийн нэгдсэн улсын элч төлөөлөгчдийг бүрэлгэнэ гэдэг бол "Их засаг" хуулиа мөнх тэнгэрийн зарлиг гэж үздэг байсан Чингис хааны хувьд бүр ч тэсвэрлэшгүй доромжлол байсан учраас тийнхүү ариун дайнд мордож байжээ.

Эрдэмтэн, зохиолч Л.Түдэв нэгэнтээ "Их монголын эзэнт гүрний захидал харилцаа дамжуулагч гол хүн нь элч, элчин хэргэм зэрэгтэй "дуун бариулах" албатай байсныг "Монголын нууц товчоо"-нд дээрх хоёр үг хорь гучин удаа

давтагддагаас гадна "дуун бариулах" зан үйл таван удаа гардгаас илэрхий болно. Түүнээс гадна "хэлэх үг элчийн аманд буй" гэдэгт итгэх аргагүй нэгэн тохиолдол бол тэр "Элч" гээд ирж байгаа хүн өөрөө жинхэнэ элч мөн үү, биш үү гэдэгт итгэхгүй гайхах зүй ёсны эргэлзээ юм. Түүнийг үгүй болгох зорилгоор төрийн элчин юм уу, цэргийн элч хүнд бас алт, мөнгө, модон гэрэгэ зүүлгэх юм уу, өвөртлүүлэн явуулдаг байжээ. Тийм гэрэгэг дээд талдаа зүүх, ганзгалах нүхтэй зууван булантай гонзгой пайз хэлбэртэй үйлдэж алт, мөнгөн дээр "Мөнх тэнгэрийн хүчин дор, их суу залийн эрхэн дор, хааны зарлиг, хэн үл бишрэх хүмүн алдах, үхэх" гэсэн бичиг хөөмөлдөж төвийлгөн сийлж хийдэг байжээ" хэмээн тэмдэглэсэн байдаг.

Монголын их гүрний үед элчийг төрийн чухал алба залгуулагч хэмээн үзэж, нэн хүндэтгэлтэй ханддаг байсны зэрэгцээ бас хариуцлагыг өндөрт тавьдаг байжээ. XIII зууны үед Монголд ирж байсан Гильом де Рубруккийн тэмдэглэлд монголын хуулинд "Элч төлөөлөгч биш атлаа өөрийг элч төлөөлөгч гэж худал хэлсэн хүнийг алж шийтгэнэ" гэж заасан тухай өгүүлсэн байдаг. Энэ нь элчийн халдашгүй байдлыг хамгаалахын зэрэгцээ түүний онцгой үүргийг дархлах санааны илрэл мөн байв.

Ашигласан материал

1. Жүдэр Ч. 1990. Чингисийн төрийн үзэл, цэргийн урлаг. УБ.
2. Дулам С. 2001. Монголчуудын бэлгэдэл зүй. III дэвтэр. УБ.
3. Фридрих И. 1979. История письма. М.
4. Окладников А. П. 1972. Центрально-Азиатский очаг первобытного искусства. Новосибирск.
5. Санжмятав Т. 1995. Монголын хадны зураг. УБ.
6. Пэрлээ Х. 1976. Монгол түмний гарлыг тамгаар хөөж судлах нь. УБ.
7. Бүрээчин Дархан. 2002. Дундад улсын сонин сэтгүүлийн түүхэн тойм. Хөх хот.
8. Түдэв Л. 1988. Ам цагаан цаасан биет, алтан номын үсгэн хэлт. УБ.

9. Рубрук Г. 1988. Дорно этгээдэд зорчсон минь. УБ.

Резюме

В настоящей статье автор даёт описание древнейшим видам коммуникации и передачи информации. В частности, автор уделяет внимание таким видам информационной коммуникации, как сигналы, вещество, рисунки, печать, устная речь и послание, с помощью которых древние обитатели нашей страны решали свою информационную нужду. По мнению автора, именно благодаря этим видам родилась новая, совершенная форма передачи информации — СМИ.